



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймаг Гурвантэс сумын “Шугшаа-Уул” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/31/-НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.umnugovi@audit.gov.mn
Даланзадгад сум
2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533539 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.Аудитын санал дүгнэлт

ГУРВАНТЭС СУМЫН
“ШУГШАА УУЛ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ЭРХЭМБАЯР ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь аймаг Гурвантэс сумын “Шугшаа Уул” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тус байгууллагын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Бусад урт хугацаат өр төлбөр дансанд 2018-2020 онуудад хандив тусламжаар орж ирсэн 2,120.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг хойшлогдсон хөрөнгөөр бүртгэн авч 147.9 сая төгрөгийн элэгдлээр бууруулах бичилт хийгдсэнээр урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,972.3 сая төгрөг байна.

Шалгадагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 3,672.4 сая төгрөгийн хөрөнгийг байгууллага бүрэн ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Өмнөговь аймаг Гурвантэс сумын “Шугшаа уул” ОНӨААТҮГ нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 төрлөөр орлого олж ашгаа нэмэгдүүлэхээр төлөвлөсөн боловч дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахалтай холбоотойгоор 9 үйл ажиллагаа

хэвийн ажиллаж 3 төрлөөр орлого тасарч, төлөвлөгөөний гүйцэтгэл 98.3 хувийн хэрэгжилттэй ба түрээс, зочид буудал, хог хаягдал, ус цэгийн орлого тасарсан байна.

Гурвантэс сумын “Шугшаа Уул” ОНӨААТҮГ-т төрөөс цэвэр, бохир усны үнийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 01-08 дугаар саруудад 35.7 сая төгрөг, 2021 оны 09, 10 дугаар саруудад 15.4 сая төгрөг, нийт 51.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Бусад асуудал

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын “Шугшаа уул” ОНӨААТҮГ-ын дотоод журамд байгууллагыг сумын ИТХ, засаг даргын хяналтан дор захирал удирдан өөрсдийн хүлээсэн үүргийн дагуу үйлдвэрлэлийн гүйцэтгэл үр дүнг тооцуулж ажиллана ” гэж заасан байна.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	136.5	136.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,005.6	3,672.4
	Нийт хөрөнгийн дүн	4,142.1	3,809.3
	Нийт өр төлбөрийн дүн	2,123.1	1,973.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,019.0	1,836.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,142.1	3,809.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	501.8	569.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	716.8	746.4
	Үйл ажиллагааны үр дүн	(215.0)	(176.7)
	Үйл ажиллагааны бус үр дүн	1.8	6.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(216.8)	(182.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,235.8	2,019.0
	Тайлант оны үр дүн	(216.8)	(182.7)
	Эцсийн үлдэгдэл	2,019.0	1,836.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	351.6	400.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	371.7	397.3
	Үйл ажиллагааны ЦМГ	20.1	2.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	20.1	2.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83.0	62.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62.9	65.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
	Урсгал зардал		
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймаг Гурвантэс сумын “Шугшаа Уул” /ОНӨААТҮГ/-ын зорилго нь хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангах, хэрэглэгчдийг дулаан хангамжаар тасралтгүй найдвартай ханган, ажилчин албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах орчин нөхцлийг бүрдүүлэн, иргэдэд нээлттэй, хүртээмжтэй, үнэнч шударга үйлчилж тасралтгүй хэвийн жигд ажиллагааг хангахад оршино. Байгууллагын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✚ Цэвэр бохир усны шаардлагатай шинжилгээг цаг тухай бүр өгөх;
- ✚ Ажилчин албан хаагчдыг мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч, ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- ✚ Ажлын цагаа баримталж соёлтой боловсон харилцааг бий болгох;
- ✚ Хэрэглэгчдийн тав тухтай амьдрах боломжийг бүрдүүлэх;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай ба өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бусад урт хугацаат өр төлбөр дансанд 2018-2020 онуудад хандив тусламжаар орж ирсэн 2,120.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг хойшлогдсон хөрөнгөөр бүртгэн авч 147.9 сая төгрөгийн элэгдлээр бууруулах бичилт хийгдсэнээр урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,972.3 сая төгрөг байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 3,672.4 сая төгрөгийн хөрөнгийг байгууллага бүрэн ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Өмнөговь аймаг Гурвантэс сумын “Шугшаа уул” ОНӨААТҮГ нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 төрлөөр орлого олж ашгаа нэмэгдүүлэхээр төлөвлөсөн боловч дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахалтай холбоотойгоор 9 үйл ажиллагаа хэвийн ажиллаж 3 төрлөөр орлого тасарч, төлөвлөгөөний гүйцэтгэл 98.3 хувийн хэрэгжилттэй ба түрээс, зочид буудал, хог хаягдал, ус цэгийн орлого тасарсан байна.

Гурвантэс сумын “Шугшаа Уул” ОНӨААТҮГ-т төрөөс цэвэр, бохир усны үнийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 01-08 дугаар саруудад 35.7 сая төгрөг, 2021 оны 09, 10 дугаар саруудад 15.4 сая төгрөг, нийт 51.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх

нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 29.2 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 24.7 сая төгрөгийн 6 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 4.5 сая төгрөгийн 4 зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 29.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 77.5 сая төгрөгийн түвшинээс 48.3 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга байхгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

8.3 Албан шаардлага

1.Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 142 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь байршуулж, сар бүр оруулахаас 3 мэдээлэл, бүтэн жил оруулахаас 2 мэдээлэл, нийт 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй, дахин давтагдсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т: “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” гэж заасантай нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлэн зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

2.Батлагдсан төсөвт зардлаас хэтрүүлэн зарцуулсан 15.5 сая төгрөг, төлөвлөгөөнд тусгагдаагүй 9.2 сая төгрөг байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д: “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Өмнөговь аймгийн засаг даргатай байгуулсан 2021 оны гэрээний 3.4-д: “Захирал нь ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг чанартай сайн зохион байгуулж ажиллах ба бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй зарцуулах зайлшгүй шаардлагатай зардлыг тодотголд тусгах асуудлыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

Цахим төлбөрийн системтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд цахим төлбөрийн системд нийт 0.6 сая төгрөгийн баримт шивэгдээгүй, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй байгааг хянаж, залруулаагүй байна.

1.1. Эрсдэл:

Цахим төлбөрийн системд тавих хяналт хангалтгүй байх.

3Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д: " дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх" гэж заасныг мөрдөж ажиллах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" гэж заасны дагуу 2021 онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

2.2. Эрсдэл:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын заалтыг хэрэгжүүлээгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, байгууллагын дотооддоо хяналт шалгалтын баг ажиллуулах

3. Мөнгөн гүйлгээний тайланттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Мөнгөн гүйлгээний тайланд андуурсан 3.8 сая төгрөгийн ажил гүйлгээг хаалтын бичилт хийлгүй орлогоор бүртгэж тайлагнасан байна.

3.2. Эрсдэл:

Орлого буруу тайлагнасан байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д: "үнэн зөв байх" гэж заасныг баримталж ажиллах

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ад хамр аглах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААҮГ	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

[illegible]